

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

20 25 оны 08 сарын 21 өдөр

№ R-2025-35

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны ТУЗ-ийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

**ТЭМДЭГЛЭХ нь:**

- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭҮХ") нь 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хурлаараа гаргасан шийдвэрийн үр дүнд, Банкны эрх бүхий албан тушаалтан болон хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдүүдэд олгох, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий нийт 199,000,000 (зуун ерэн өсөн сая) төгрөгийн үнийн дүнтэй 2 зээл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд")-ийг батламжлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй өрдийн нөхцөлөөс давуу тал олгоогүй болохыг ЭҮХ тодорхойлсон болохыг; мөн
- ТУЗ нь ЭҮХ-ноос санал болгосны дагуу батламжлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

**ТОГТООХ нь:**

- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хавсралт ёсоор батламжилсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГУПТА

Н.МОНХЦЭЛМЭГ

## ХАСБАНК ХК

**Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батламжилсан талаарх мэдээлэл**

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/

Тайлагнах хугацаа	2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	<p>Нэр: ХасБанк ХК</p> <p>УБГД: 000239852</p> <p>РД: 2578697</p> <p>Үнэт цаасны код: MN00XAC05687</p> <p>Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72</p> <p>Утас: 75771888</p> <p>И-мэйл: info@xacbank.mn</p> <p>Вэбсайт: www.xacbank.mn</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: Н.Цэлмэгхишиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч</p> <p>Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</p>
1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батламжилсан талаарх мэдээлэл	ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-35 тоот тогтоолоор, Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу, Банкны эрх бүхий албан тушаалтан болон хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдүүдтэй байгуулсан нийт 199,000,000 (зуун өрэн есөн сая) төгрөгийн үнийн дүн бүхий 2 (хоёр) хэлцлийг батламжилсан болно. Энэхүү хэлцлүүд нь Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны өрдийн үйл ажиллагааны хүрээнд олгогдсон, гуравдагч этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг хангасан болно.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Цэлмэгхишиг

Албан тушаал: ТУЗ-ийн ажлын албаны хуульч


Гарын үсэг:



Хянасан: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Огноо: 2025 он 08 сар 26 өдөр